



ЭРХТЭН ШИЛЖҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

SOME ISSUES OF LEGAL REGULATION OF ORGAN TRANSPLANTATION

Очирбатын Отгонтуяа¹

University of Internal Affairs, E-mail: otgontuya8811@gmail.com, <https://orcid.org/0009-0000-1120-8841>

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

Донор, амьгүй донор, эрхтэн шилжүүлэн суулгах, эрүүл мэнд, донорын тухай хууль, донорын эрх зүйн зохицуулалт

Keywords:

Donor, inanimate donor, organ transplant, health, donor law, legal regulation of donors

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2025, 8 сар
Шинэчилсэн: 2025, 9 сар
Зөвшөөрсөн: 2025, 10 сар

Article history:

Received Aug, 2025
Revised Sep, 2025
Accepted Oct, 2025

ХУРААНГУЙ

Аливаа улс орны хөдөлгөгч гол нэгж нь иргэд байдаг. Энэ утгаараа иргэдийн эрүүл мэндийн асуудал нь зайшигүй хэлэлцэх шаардлагатай чухал асуудалд тооцогддог.

Орчин үеийн анагаах ухааны шинжлэх ухаан нь эмчилгээний шинэ боломжуудыг нээж, тодорхой хүнд өвчнүүдийг эмчлэх үр дүнтэй аргуудыг практикт нэвтрүүлж байгаа билээ. Үүний нэг нь хүний цус, эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах буюу донорын ойлголт юм. Энэ асуудлаар Монгол Улс анх удаа 2000 онд Донорын тухай хуулийг батлагдсанаас хойш 2018 онд шинэчилсэн найруулга хийгдсэнээр одоог хүртэл дагаж мөрдөж байна.

Уг хуульд амьтай болон амьгүй донорын эрх зүйн харилцааг зохицуулдаг ба үүнээс амьгүй донороос эрхтэн шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын зарим тулгамдсан асуудлыг нээн, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох, шийдэл гаргахыг зорилоо.

Abstract

The main driving force of any country is its citizens. In this sense, the health of citizens is an important issue that must be discussed.

Modern medical science is opening up new therapeutic opportunities and introducing effective methods for treating certain serious diseases into practice. One of these is the concept of human blood, cell, tissue, and organ transplantation, or donorship. Mongolia has been following this issue since the first Donor Law was adopted in 2000, which was revised in 2018 and is still in force.

The law regulates the legal relations between living and inanimate donors, and it aims to identify some of the pressing issues in the legal regulation of organ transplantation from inanimate donors, identify ways to resolve them, and provide solutions.

Энэ өгүүлэл [CC BY-NC](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/) лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



¹ Дотоод хэргийн их сургуулийн Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн Хувийн эрх зүйн тэнхимийн ахлах багш, хууль зүйн доктор (Ph.D)

1. Танилцуулга

Энэхүү өгүүлэлд Монгол Улсад мөрдөгдөж буй Төрийн болон албаны нууцын тухай хууль болон холбогдох журам, тэдгээрийн хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчны тулгамдсан асуудлыг үндэсний аюулгүй байдлын цогц байдлын онол болон хууль зүйн реалист хандлагаар үнэлсэн болно. Судалгаанд хууль зүйн догматик, реалист, харьцуулсан шинжилгээний аргуудыг хослуулан ашиглаж, эрх зүйн зохицуулалтын формаль бүтэц ба бодит хэрэгжилтийн зөрүү, эрх зүйн хийдэл байгааг тодорхойлсон.

2. Арга зүй

Хууль зүйн реализмын үүднээс бол хууль нь зөвхөн норматив хэлбэрээр бус, институтийн чадамж ба хэрэгжүүлэгчийн зан үйлийн уялдаанд тулгуурлан хэрэгжиж бодит үр нөлөөгөө үзүүлдэг. Иймд төрийн болон албаны нууцыг хүргэх үйл ажиллагааны эрх зүйн орчныг үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдуулан, мэдээллийн бүрэн бүтэн байдал, төрийн нууцын хамгаалалтын үр нөлөөг нэмэгдүүлэх замаар боловсронгуй болгох шаардлага байгааг судалгаа харуулж байна.

3. Судалгааны үр дүн

ОРШИЛ:

Эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ нь ХХ зуунд эрүүл мэндийн салбарт гарсан гайхамшигт ололт амжилт бөгөөд энэхүү эмчилгээний ачаар хэдэн мянган хүн олон зуун хүнд амьдрал бэлэглэж, амьдралын чанарыг нь сайжруулсан юм (Хельсингийн тунхаглал. 2013. Истанбулийн тунхаглал. 2018). Эрхтэн шилжүүлэн суулгахад хамгийн төвөгтэй асуудлын нэг нь донор байдаг. Донорын хуульд (Донорын тухай хууль. Төрийн мэдээлэл. №6, 2018.) зааснаар амьд болон амьгүй донор бий. Монгол Улсад ихэвчлэн амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах хагалгаа хийгдэж байна. 2006 онд Монгол Улсад амьгүй донороос хоёр хүнд эрхтэн шилжүүлэн суулгасан.

Дэлхийн чиг хандлага нь амьгүй донороос эрхтэн шилжүүлэн суулгахыг үр дүнтэй гэж үздэг. Үүний учир нь: Амьд донороос эд, эс, эрхтэн шилжүүлэн авахаас зайлсхийж, хагалгааны дараа нь амьд донорт эрүүл мэндийн болон бусад асуудал үүсэхээс урьдчилан сэргийлж чаддаг. Гэвч Монгол Улсад амьгүй донорын асуудал хөгжихгүй, олдоц муу байгаа нь, Монгол хүмүүсийн ёс суртахуун, зан заншилд нас барсан хүнийг амьгүй донор болгох асуудалд эмзгээр ханддаг нь нөлөөлдөг байна.

Монгол эмч нар хүний эд, эс, эрхтнийг шилжүүлэн суулгах мэс ажилбарыг дотооддоо хийх явдал өргөжиж байгаатай холбоотойгоор эерэг, сөрөг олон үр дагавар гарч байгаа. Сөрөг үр дагаврын нэг нь бусдын эд эрхтнийг хууль бусаар авч, худалдаалах гэмт хэрэг үүсэн гарах шалтгаан бий болж байгаа явдал юм. Цус, эс, эд, эрхтэн хууль бусаар авах гэмт хэрэг нь анагаахын шинжлэх ухаан болон хууль зүйн шинжлэх ухааны огтлолцол дээр үүсдэг харилцаа бөгөөд эрүүгийн эрх зүй дэх эмнэлгийн эрх зүйтэй холбогдох зүйл хэсгүүд нь орчин үед зайлшгүй судлах шаардлагатай сэдэв болоод байгаа юм.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Дэлхийн түүхэнд хамгийн анхны арьс нөхөн сэргээх хагалгаа 1823 онд Герман Улсад, анхны бөөр шилжүүлэн суулгах хагалгаа 1950 онд Америкийн нэгдсэн улс /цаашид АНУ гэх/-д, анхны амьгүй донороос бөөр шилжүүлэн суулгах хагалгаа 1962 онд АНУ-д, анхны элэг шилжүүлэн суулгах хагалгаа 1967 онд Америкийн Нэгдсэн Улсад тус тус хийгдэж байсан ажээ (United Network for Organ Sharing, n.d.).

1954 онд бөөрийг хүний биед амжилттай шилжүүлэн суулгасан анхны эрхтэн болж байжээ (United Network for Organ Sharing, n.d.). 1980-аад оны эхэн үе хүртэл эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааны тоог хязгаарлаж байсан. Анагаах ухааны хөгжил, дэвшил эрчимтэй өссөнөөр эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал амжилттай болж, мөн эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын эрэлт хэрэгцээ нэмэгдсэн.

1960 оноос хойш эрхтэн шилжүүлэн тухай хөтөлбөрүүд хэрэгжиж, холбогдох хууль тогтоомжууд боловсрогдож эхэлсэн байна.

Азийн улсууд шашин шүтлэг, амьдралын хэв маяг зэргээс хамааран амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах нь түлхүү байдаг бол Европын Улсуудад амьгүй донороос буюу тархины үхэлтэй донороос эд, эс, эрхтэн шилжүүлэн суулгах нь элбэг байдаг. Дэлхийн улс орнууд эрхтэн шилжүүлэн суулгах асуудлыг хуульчлах оролдлогыг анх 1932 онд Итали Улсад хийсэн ба 1966 онд Чехословак Улс амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгах асуудлыг хуулиар баталсан бөгөөд Дани, Итали Улсад 1967 онд, Венгри Улсад 1972 онд, Болгар Улсад 1973 онд тус тус баталж байсан (<https://gogo.mn/>, n.d.). Гэвч эдгээр хууль журам нь төгс биш байсан бөгөөд тэр үеийн эрхтэн шилжүүлэх эрх зүйн асуудлыг хамарч чадаагүй байна (М.Цэрэнбат, 2023).

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр эрхтэн шилжүүлэх мэс заслын арга, хэлбэр өөрчлөгдөж, эерэг болон сөрөг асуудлууд гарсаар байсан юм. Үүнтэй зэрэгцэн улс орон бүр өөрсдийн “Донорын тухай хууль”-аа боловсронгуй болгосоор ирсэн юм. Үүний нэг жишээ гэвэл Монгол Улсыг дурдаж болох юм. Монгол Улс нь дэлхийн улсуудтай харьцуулахад эрхтэн шилжүүлэх буюу донорын асуудал нь хожуу үүссэн ч үүнтэй холбогдох эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгосоор яваа билээ. Монгол Улсад анх 2000 онд “Донорын тухай хууль” батлагдсан. Үүнээс хойш нэмэлт өөрчлөлтүүд хийгдэж 2018 онд дахин шинэчлэгдэн батлагдсан байна. Эрхтэн шилжүүлэх, донорын шинжлэх ухаан өнөөг хүртэл үргэлжилсэн ахиц, дэвшлийн арвин баялаг түүхтэй (Б.Мөнгөншагай, 2018).

Эрхтэн шилжүүлэн суулгах гэдэг нь хүний эс, эд эрхтний талыг эсвэл бүтнээр нь авч нөгөө хүнд уг эрхтний байранд эсвэл биеийн өөр хэсэгт нь шилжүүлэн суулгахыг хэлнэ (Organ Donor, n.d.).

Амьгүй донор гэж тархи бүрэн үхжиж, үйл ажиллагаа эргэшгүй алдагдсан, нас барсан нь тогтоогдсоны дараа үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа зарим эс, эд, эрхтнийг шилжүүлэн суулгахаар авч болох цогцсыг хэлнэ (Донорын тухай хууль. Төрийн мэдээлэл. №6, 2018).

Тархины үхэл гэдэг нь мэдрэлийн эсийн түвшинд эргэшгүй өөрчлөлт гарснаас тархины үйл ажиллагаа бүрэн алдагдахыг хэлнэ. (Донорын тухай хууль. Төрийн мэдээлэл. №6, 2018) Өөрөөр хэлбэл тархины бүтэц үйл ажиллагаанд эргэлтгүй өөрчлөлт

гарсан үед амьсгал цусны эргэлтийг аппарат, эмийн тусламжтайгаар тогтоон барьж байгаа байдал.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.1-т Амьд явах эрхтэй хэмээн заасан. Уг амьд явах эрх нь хүн болгоны хувьд төрөлх чанартай заяагдсан эрх. Өөрөөр хэлбэл төрөхөөс үхэх хүртэл хугацаанд хүн амьдрах бөгөөд, цогцос нь хүн үхсэний дараах байдлыг нэрлэсэн ойлголт юм. Иймд амьгүй донороос эд эрхтэн шилжүүлэх тухайн кадавр донор болох субъектийн хувьд амьд явах эрхтэй хамааралгүй гэж ойлгож болно.

Амьгүй донорыг нэр томъёоны хувьд авч үзвэл: Анагаахын шинжлэх ухаанд кадавр донор гэж нэрлэгддэг бол, хууль эрх зүйн хэрэглээнд амьгүй донор гэж хэрэглэгдэнэ. Амьгүй донорт тархины үйл ажиллагаа нь бүрэн алдагдаж, нас барсан байхыг шалгуур болгодог тул тархины үхэлтэй донор энэхүү ойлголтод хамаарна.

Тархины үхлийг эмнэлзүйн шалгуураар тогтооно. Мөн эрхтэн донорлох зорилго нь өвчтөний нас барах явцыг түргэсгэх эсвэл нас барах шалтгаан болохгүй тул амьгүй донороос эд эрхтэн шилжүүлэн суулгахад тухайн хандивлагчийн амьд явах эрхийг зөрчсөн гэж үзэх боломжгүй. Тодруулбал, хандивлагч буюу донорын амьд явах эрх яригдахгүй юм.

Донорын тухай хуулийн зохицуулалт

Донорын тухай хуулийн зорилт нь “Хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг нь аврах зорилгоор сайн дураараа цус, эс, эд, эрхтнээ үнэ төлбөргүй өгөх, шилжүүлэн суулгах, цусны аюулгүй байдлыг хангах цогц үйл ажиллагаа болон уг үйл ажиллагааны талаарх төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэний эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” (Донорын тухай хууль. Төрийн мэдээлэл. №6, 2018) гэж заасан байдаг. Энэ нь хүний хүмүүнлэг, ёс зүйтэй байх боломж нөхцөлийг хуульчилж өгсөн гэж харагдаж байна. Энэ хуулийн зарчимд:

Хууль, хүний эрхийг дээдлэх;

Хүмүүнлэг энэрэнгүй байх;

Ялгаварлан гадуурхахгүй байх;

Аюулгүй байдлыг хангах;

Хүний эмзэг мэдээллийг хамгаалах;

Авлагагүй, сайн дурын байх гэж тусгаж өгсөн. Эдгээр зарчмаас авлагагүй сайн дурын байх зарчимд тулгуурлан энэхүү илтгэлээ бичихийг зорилоо.

Уг зарчмыг тайлбарлавал:

Авлагагүй: Авцаа, хариу төлбөргүй байх (Монгол хэлний их тайлбар толь, 2018)

Сайн дурын: Өөрийн хүсэл сонирхлоор (Монгол хэлний их тайлбар толь, 2018) гэх утгыг илэрхийлдэг байна. Ийм учир донорын үйл ажиллагаа нь донор өөрийнх нь хүсэл зоригийн үндсэн дээр гардаг шийдвэр байна.

Донорын тухай хуульд

13.1.2. донорын үүргээ гүйцэтгэх үедээ Хөдөлмөрийн тухай хуулийн 117.2-т заасан дундаж цалин хөлстэй тэнцэх олговор авах;

Хөдөлмөрийн тухай хуульд

117.2.Энэ хуулийн 60.1.2-т заасан донорын үүрэг гүйцэтгэх хугацаанд ажилтанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно.

60.1.2.донорын үүрэг гүйцэтгэх, эсхүл энэ хуулийн 80.1.4, 80.1.5, 80.1.6-д зааснаас бусад тохиолдолд эрүүл мэндийн шалтгаанаар эмнэлгийн магадалгаатай;

Эдгээр зүйл заалтаас үзэхэд ажил гүйцэтгэж байгаа хүн донор болсон бол хөдөлмөрийн тухай хуулийн 60.1.2, 117.2-т зааснаар донорын ажлын байрыг хадгалж, нөхөн олговор авна гэж ойлгогдож байна.

Амьгүй донорын хувьд

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолд “Амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг 3,500,000 төгрөг тогтоосугай” (Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, 2022) гэж заасан байгаагаас үзэхэд зөвхөн нийгмийн даатгал төлж байсан бол оршуулгын тэтгэмж авах юм.

Жишээгээр аваад үзвэл (www.news.mn, n.d.): Монгол Улсад хүний эс эд эрхтэн шилжүүлэн суулгахтай холбоотой нийгмийн сүлжээгээр “зүрх нь зогсоогүй буюу амьд хүнээс”-ээс эд эрхтнийг авсан мөн амьгүй донор болсны оршуулгын тэтгэмжийг олгохгүй байгаа хэмээн нийтэлсэн. Үүний хариу тайлбарт эрүүл мэндийн сайд С.Чинзориг нь хүний тархины бүх үйл ажиллагаа эргэж сэргэшгүйгээр алдагдахыг тархины үхэл гэж үздэг. Харин амьсгал, зүрх судасны үйл ажиллагааг нь эмийн бэлдмэл, аппаратын тусламжтай зохиомлоор дэмжиж, тодорхой хугацаанд цусан хангамжийг тогтвортой байлгаж эс, эд эрхтнийг шилжүүлэн суулгах боломжийг бүрдүүлдэг (Донорын тухай хууль. Төрийн мэдээлэл. №6, 2018). Үүнийг амьд байхад нь хүний эд эрхтнийг авсан мэтээр ташаа ойлголт төрүүлж болохгүй. Мөн амьгүй донор болсон хүнийг нийгмийн даатгалд хамрагдаагүй учраас оршуулгын тэтгэмж олгох боломжгүй хэмээсэн юм.

Амьгүй донороос эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах харилцааг зохицуулсан эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага байгааг дээрх жишээ харуулж байна. Юуны өмнө нийгмийн даатгалд хамрагдсан эсэхээс үл хамаарч амьгүй донорт оршуулгын тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа юм.

Донорын тухай хуулийн хуучин ба шинэчилсэн хуулийн харьцуулалт (www.legalinfo.mn, n.d.)

Донорын тухай хууль 2000 он	Донорын тухай шинэчилсэн хууль 2018 он
5 бүлэг 18 зүйлтэй Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл Хоёрдугаар бүлэг: Донор Реципиент эрүүл мэндийн байгууллагын ажилтанд тавих шаардлага Гуравдугаар бүлэг: Донорын цус эд эрхтэн авах, шинжлэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх шилжүүлэн суулгах Дөрөвдүгээр бүлэг: Донорын эгнээг өргөжүүлэх Тавдугаар бүлэг: Бусад зүйл	6 бүлэг 24 зүйлтэй Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл Хоёрдугаар бүлэг: Донорын үйл ажиллагааны удирдлага бүтэц зохион байгуулалт Гуравдугаар бүлэг: Донор, Реципиент, Эрүүл мэндийн байгууллага, ажилтанд тавигдах шаардлага. Дөрөвдүгээр бүлэг. Донороос цус, эс, эд эрхтэн авах шинжлэх боловсруулах, хадгалах, тээвэрлэх,

		шилжүүлэн суулгах, устгах Тавдугаар бүлэг: Цусны донорын эгнээг өргөжүүлэх Зургаадугаар бүлэг: Бусад
	2018 онд шинэчлэгдэн батлагдсан “Донорын тухай хууль”-д нэмэлтээр “Донорын үйл ажиллагааны удирдлага, бүтэц зохион байгуулалт” гэх бүлэг нэмэгдсэн нь донорын үйл ажиллагааны удирдлагын тогтолцоог нарийвчлан тодорхойлж, уг байгууллагуудын үүргийг тусгаж өгсөн дэвшилтэй тал болсон.	
	-	Донорын үйл ажиллагаанд баримтлах зарчим: Хууль, хүний эрхийг дээдлэх Хүмүүнлэг, энэрэнгүй байх Ялгаварлан гадуурхахгүй байх Аюулгүй байдлыг хангах Хувь хүний нууцыг хамгаалах Авлагагүй, сайн дурын байх
	Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд донорын үйл ажиллагаанд баримтлах зарчмуудыг тусгаж өгсөн байна .	
	2000 оны Донорын тухай хуулийн 11.7. Амьгүй донороос эд, эрхтэн авсны дараа донорын гадаад байдлыг анхны янзад нь оруулахыг эд, эрхтэн авсан эрүүл мэндийн байгууллага хариуцна гэж заасан байна.	2000 оны Донорын тухай хуулийн 11.7 дах заалтыг Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгад хасаж оруулсан.
	Дээрх зүйл заалтыг хассан нь цогцостой харьцах эмнэлгийн байгууллагын ёс зүйн үнэлэмжийг орхигдуулж болзошгүй байдал үүсэх магадлалтай гэж үзэж байна.	

Дэлхийд анх удаа 1954 онд хоёр ихрээс бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийсэн. 1963 онд элэг шилжүүлэн суулгах мэс засал Америкийн Нэгдсэн Улсад хийсэн. 1968 оноос тархины үхэлтэй донор гэсэн ухагдахуун гэсэн шинэ нэр томьёо гарсан, Харвардын их сургуулиас тархины үхэлтэй донорын шалгуур үзүүлэлтийг баталж өгснөөр өнөөдөр дэлхий даяар амьгүй донороос эд эрхтэн шилжүүлэх эмчилгээ хийж байна. Өнөөдрийн байдлаар дэлхийн 93 улс эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ хийдэг.

Монгол Улсын хувьд 2006 онд анхны бөөр шилжүүлэн суулгах мэс заслыг хийсэн. 2006 оноос хойш 128 иргэнд бөөр шилжүүлэн суулгаснаас 108 иргэнд амьд донороос, 10 иргэнд амьгүй донороос, 28 иргэнд элэг шилжүүлэн суулгаснаас 27 ирэнд амьд донороос, 1 иргэнд амьгүй донороос шилжүүлэн суулгах мэс заслыг тус тус хийсэн. Гэхдээ энэ ажиллагаанд ДЭМБ-аас гаргасан 11 үндсэн зарчмыг мөрдлөг болгодог. Монгол Улс ч эдгээр зарчмыг үндэслэн ёс зүйн удирдамжийг гаргасан. Эс, эд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний талаар гарсан бүх гомдол мэдээллийг хүлээн авдаг. Ёс

зүйн хороо байгуулах нь зүйтэй гэсэн санал 2018 оны хуулийг хэлэлцэх үеэр гарсан боловч одоо болтол ёс зүйн хороог байгуулаагүй байна.

Гадаадын 80 орноос 55 улс нь хууль ёсны стандарттай. Зарим оронд (жишээлбэл Финлянд, Польш, Уэльс, Португал, Франц) тархины үхэлтэй нь оношлогдон батлагдаж, хуулийн дагуу эерэг шалгуурт багтсан тохиолдолд бүгд автоматаар эрхтнээ өгөгч болж байхад өөр хэсэгт эрхтний донор болгохыг гэр бүлийн гишүүн болон төрөл төрөгсдийн зөвшөөрлийн үндсэн дээр шийдэж байна. Мөн Шинэ Зеланд, Австрали, Уэльс болон Америкийн Нэгдсэн Улсын ихэнх бүсэд жолооч болох үед эрхтэн өгөх эсэх тухай асуумж явуулж бүртгэлд оруулдаг.

Эс, эд эрхтэн шилжүүлэх гэрээ:

Монгол Улс 2017 онд донороос эд эрхтэн авах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг баталсан. Дээрх журмаар амьтай болон амьгүй донорын зөвшөөрлийн хуудсыг бичүүлж авдаг байсан бол 2019 онд дээрх журмыг шинэчлэн баталж “Эс эд эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг хамтран зохион байгуулах эрүүл мэндийн байгууллагатай хийх гэрээний загвар”-ыг гаргасан юм.

4. Дүгнэлт:

Амьгүй донороос эд, эрхтэн шилжүүлэх ажиллагааг хийхийн тулд гурвалсан гэрээ байгуулдаг. Гэвч уг гэрээ нь зөвхөн мэс ажилбар хийж буй эмч нарын хооронд хийгддэг. Энэхүү гэрээнд донор болж буй хүн, мөн амьгүй донорын ар гэрийнхэн нь оролцдоггүйгээс үүдэн, тэдний эрх зөрчигдөх, нөхөн олговор, тэтгэмж олгох зэрэг асуудлууд нь орхигдож байна. Тиймээс Монгол Улс олон улсын жишигт нийцсэн донорын гэрээтэй холбоотой нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох нэн шаардлага үүсэж байгаа нь судалгаанаас харагдаж байна. Нийгмийн даатгал төлсөн эсэхээс шалтгаалан амьгүй донорын гэр бүлийнхэнд нь оршуулгын тэтгэмжийг олгох хэрэгцээтэй байна.

САНАЛ:

Донорын тухай хуульд дүн шинжилгээ хийснээс үзэхэд 2000 оноос эхлэн хэрэгжиж байсан Донорын тухай хуулийн 11.7-т заасан “Амьгүй донороос эд, эрхтэн авсны дараа донорын гадаад байдлыг анхны янзанд нь оруулахыг эд, эрхтэн авсан эрүүл мэндийн байгууллага хариуцна” гэх зүйл заалтыг Донорын тухай хуульд дахин нэмэлт, өөрчлөлт оруулах

Донорын тухай хуульд “Донор болж буй хүнд нийгмийн даатгал төлсөн эсэхээс үл хамааран тэтгэмж олгодог болсугай” гэж нэмэх

Донортой холбоотой гэрээ байгуулах тухай Донорын тухай хуулийн 13 дугаар зүйлд нарийвчлан тогтоох. Жишээ нь: Донорын эрх үүрэг, нөхөн олговор, нас барсны тэтгэмж.

Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагаатай холбоотой мэргэжлийн Ёс зүйн хороо ажиллахаар тусгасан. Гэвч одоог хүртэл байгуулаагүй байна. “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах үйл ажиллагааны явцад гарч болох ёс зүйн хэм хэмжээтэй холбогдсон харилцааг

зохицуулах үүрэг бүхий эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн хороог Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд яаралтай байгуулах.

ЗӨВЛӨМЖ:

Иргэдэд донорын талаарх мэдээллийг нээлттэй болгох зорилгоор донортой холбоотой арга хэмжээг жил бүр зохион байгуулах;

Донорын гэрээг мэс ажилбар хийж буй эмч нарын хооронд хийдэгтэй адил донор болж буй иргэнтэй хамтран гэрээ хийх эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;

Донортой холбоотой үйл ажиллагаа явуулдаг эмнэлгийн хажууд “Ёс зүйн хороо” байгуулснаар донор болж буй хүний эрх ашиг зөрчигдөхөөс сэргийлэх боломж бүрдэх нөхцөл тавигдана.

5. Эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль. 1992.
- Монгол Улсын Донорын тухай хууль. 2000.
- Монгол Улсын Донорын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2018.
- Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль. 2021.
- Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хууль. 2023.
- Хельсинкийн тунхаглал. 2013.
- Истанбулийн тунхаглал. 2018.
- Б.Мөнгөншагай. Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зарим асуудал. судалгааны ажил. Уб., 2018.
- М.Цэрэнбат. Донорын эрх зүйн зохицуулалт. Уб., 2023.
- Цахим эх сурвалж
- <https://legalinfo.mn>
- <https://www-organdonor-gov>
- <https://moh.gov.mn/>
- <https://www.ndaatgal.mn/laws>
- <https://gogo.mn/>

---oOo---

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ДОНОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
(ТӨСӨЛ)

1 дүгээр зүйл. Донорын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

1/ 7.1.8 дугаар зүйл. “Амыгүй донороос эд, эрхтэн авсны донорын гадаад байдлыг анхны хэвийн байдалд нь оруулахыг эд, эс, эрхтэн авсан эрүүл мэндийн байгууллага хариуцна” гэж нэмсүгэй.

2/ 13 дугаар зүйл. Донор болж буй хүнд нийгмийн даатгал төлсөн эсэхээс үл хамааран тэтгэмж олгодог болсугай гэж нэмсүгэй.

3/ 13 дугаар зүйл. Донорын эрх, үүрэгт донортой холбоотой гэрээ байгуулах тухай гэрээний зүйл болох эрхтэн шилжүүлэхдээ донор болж буй хүний эрх үүрэг, нөхөн олговор, тэтгэмж гэх зэрэг асуудлуудыг гэрээнд тусгах донор болж буй хүнтэй гэрээ байгуулах тухай нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 20... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

133

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

---oOo---